



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР, ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Сүхбаатарын талбай-7,
Монголын Хуульчдын холбооны байр
Веб: www.mglbar.mn, И-мэйл: info@mglbar.mn
Утас: 70116364, Факс: 70116364

2019.08.14 № 1/926
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Монголын Хуульчдын холбоо нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад 5000 гаруй хуульчдыг эгнээндээ нэгтгэсэн өөрөө удирдах мөн мэргэжлийн байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд болно. Үндсэн хууль нь Монгол Улсын тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө, төрийн засаглал, бүтэц, үйл ажиллагаа явуулах үндэс, зарчмыг тодорхойлдог, улс үндэстний оршин тогтнох суурь нь мөн болох тул Монголын Хуульчдын холбооны зүгээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцыг анхааралтай ажиглаж, дуу хоолойгоо илэрхийлж ажиллаж байна.

УИХ-ын нэр бүхий 62 гишүүний зүгээс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл УИХ-д өргөн барихаас хойш болон өмнө нь Монголын Хуульчдын холбоо нь санал зөвлөмж, байр сууриа цаг тухай бүр илэрхийлэн хүргүүлж, зарим гишүүн хуульчид төсөл боловсруулах ажилд биечлэн оролцож ирсэн бөгөөд мэргэжлийн хуульч, судлаачдын санал байр суурь тодорхой хэмжээнд тусгалаа олсонд баяртай байгаагаа энэ дашрамд илэрхийлье.

УИХ-ын чуулганаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн анхны хэлэлцүүлэг хийгдсэний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас нэмэлт, өөрчлөлтөд холбогдох саналаа ирүүлж, улмаар УИХ-ын 2019 оны 72 дугаар тогтоолын дагуу УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан нарын нэр бүхий 62 гишүүний өргөн мэдүүлсэн төсөлтэй Ерөнхийлөгчийн саналыг уялдуулах, асуудлыг зөвшилцөх үүрэг бүхий Зөвшилцлийн ажлын хэсэг байгуулагдсан. 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдөр тус Зөвшилцлийн ажлын хэсгийн зүгээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөс Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зүйл, заалтыг хасах Ерөнхийлөгчийн саналыг хүлээн авахаар шийдвэрлэсэн талаар УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс УИХ-ын албан ёсны цахим хуудаснаа мэдээлжээ. Зөвшилцлийн ажлын хэсгээс гаргасан саналтай холбоотойгоор Монголын Хуульчдын холбоо “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: Хараат бус, шударга шүүх” хэлэлцүүлгийг гишүүн хуульчдын дунд 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Үе үеийн судлаач, хуульч, төрийн зүтгэлтнүүд, хөндлөнгийн судалгааны байгууллагын зүгээс удаа дараагийн зөвлөмж, санал өгч ирсэн бие даасан, хараат бус шүүхийн төлөө нэмэлт, өөрчлөлт нь энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн


“амин сүнс” гэж хэлж болох ба Зөвшилцлийн ажлын хэсгийн зүгээс хасах санал оруулсныг Хуульчдын холбооны зүгээс ухралт гэж үзэж, шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотойгоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд заавал тусгах шаардлагатай гэж хуульчид 100% санал нэгдсэн зарчмын санал, байр суурийг хүргүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн Ерөнхий зөвлөл шүүгчдийг томилох шийдвэр гаргаж, Ерөнхийлөгч батламжилдаг эрхтэй байх;
2. Ерөнхийлөгч гагцхүү Үндсэн хуульд заасан үндэслэлээр батламжлахаас татгалздаг байх;
3. Шүүхийн Ерөнхий зөвлөлийг улс төрийн байгууллага, субъектээс хараат бусаар байгуулах, гишүүдийн тоо, бүтэц, байгуулагдах журмыг Үндсэн хуульд тодорхой заах;
4. Шүүгчийн хариуцлагын хороо, хорооны бүрэлдэхүүний зохицуулалтыг улс төрөөс хараат бусаар ажиллахаар тусгах зэрэг болно.
5. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгааг Үндсэн хуулиар бэхжүүлж, эрх мэдэл хуваарилах зарчим бодитоор хэрэгжих нөхцөл, боломжийг бүрдүүлэх нь хуульчдын хувьд төдийгүй иргэн бүрийн хувьд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс тогтооход онцгой ач холбогдолтой хүмүүнлэг ардчилсан нийгмийн тулгуур багана юм.

Иймд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсэг, УИХ-ын гишүүдийг зарчмын байр сууриа хадгалж, Монгол Улсын нийтлэг эрх ашиг, хүмүүнлэг ардчилсан үнэт зүйлсийн төлөө нэгдэж ажиллана гэж найдаж байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙЛӨГЧ



Ж.ХУНАН